

НУТГИЙН УДИРДЛАГАД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН МАНЛАЙЛАЛ

Эмэгтэй төлөөлөгчдийн сайн туршлага



СОЁЛЫН ТӨВИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ШИНЭЧЛЭЛТ

1. ИТХ-ын 2018 оны 12-р сарын 17-ны өдрийн 9-р хуралдааны төсөв батлах тухай тогтоолоор Соёлын төвийн тохижилт, тоног төхөөрөмжийн зардалд Орон нутгийн хөгжлийн сангаас 10 сая төгрөг баталсан.

2. Хүүхэд, залуус, эмэгтэйчүүд, ахмад настнуудад чиглэсэн арга хэмжээг тэдний онцлогт нийцсэн байдлаар явуулах төдийгүй хөдөө багийн төвд малчдад соёлын үйлчилгээг тогтмол хүргэх боломж нээгдсэн.



Харилцах хаяг: Хэнтий аймгийн Мөрөн сумын ИТХ-ын эмэгтэй төлөөлөгчид: Н. Даваажав 98282127, Д. Пүрэвжаргал 98608079, Н. Нансалмаа 99076280, С. Энхтуул 93013125

НУТГИЙН УДИРДЛАГАД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН МАНЛАЙЛАЛ

Эмэгтэй төлөөлөгчдийн сайн туршлага



АРАВТЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ: БИНХ ДАХЬ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦОО

1. ИТХ-ын
Тэргүүлэгчдийн
хурлаар
"Эмэгтэйчүүдийн
хөгжлийн хөтөлбөр"
батлуулсан.

2. Энэ хөтөлбөрийн
төслийг
боловсруулахдаа
иргэдийн оролцоог
баталгаажуулсан
хуулийн механизмыг
ашигласан. (Хөгжлийн
бодлого төлөвлөлтийн
тухай хуульд заасан
Нээлттэй хэлэлцүүлэг)

3. Төлөөллийг
хангахын тулд аравтын
зохион байгуулалтыг
бий болгосон нь БИНХ
ба эмэгтэйчүүдийн
дунд мэдээлэл
солилцох үр дүнтэй
суваг болж байна.



Харилцах хаяг: Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын ИТХ-ын дарга Х.Даваасүрэн, Утас: 99384072,
ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга Л.Сэрсмаа, Утас: 99264604, И-мэйл: sersmaa_ts@yahoo.com

НУТГИЙН УДИРДЛАГАД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН МАНЛАЙЛАЛ

Эмэгтэй төлөөлөгчдийн сайн туршлага



МЭДЭЭЛЛИЙН БОГЦ

1. Мэдээллийг хэн ч уншаад ойлгохуйц энгийн, товч, тодорхой байдлаар бэлтгэн орон нутгийн иргэдэд шуурхай хүргэх “Мэдээллийн богц”-ыг санаачлан хэрэгжүүлсэн.

2. Иргэн бүрийн дуу хоолойг сонсч, төлөөллийн байгууллага болон иргэд хооронд хоёр урсгалтай мэдээллийн сувгийг бий болгож, эргэх холбоог бүрдүүлсэн.

3. Мэдээллийн богцыг улиралд нэг удаа сумын бүх өрхөөр аялуулдаг ба ИТХ-ын ажлын алба иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэн хариу өгдөг.



Харилцах хаяг: Булган аймгийн Гурванбулаг сумын ИТХ-ын төлөөлөгч Б.Дэлгэр,
Утас: 95950065, 80841551, и-мэйл хаяг: delgerbatbayar@yahoo.com

НУТГИЙН УДИРДЛАГАД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН МАНЛАЙЛАЛ

Эмэгтэй төлөөлөгчдийн сайн туршлага



ЗАХЫН ГЭР ХОРООЛОЛД ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГ БАРИУЛСАН

1. 1000 төгрөгний хандиваас эхлүүлэн 120 сая төгрөг босгосон ба үлдэгдэл мөнгийг бүрдүүлэхийн тулд ИТХ-д санал оруулж, жил бүрийн орон нутгийн сангаас 50 сая, 100 сая, 80 сая гэх мэт хэсэгчилсэн дүнгээр батлуулсан.

2. 3 жилийн хугацаанд нийт 420 сая төгрөг босгож, жил бүр 147 хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулах боломж бүрдүүлсэн.

3. Шинээр 21 ажлын байр бий болгосон.



Харилцах хаяг: Баянхонгор аймгийн ИТХ-ын төлөөлөгч, Нэгдсэн эмнэлгийн дотор, дуран оношлогооны их эмч Ж.Дулмаа Утас: 9928 4112, 8802 4112, и-мэйл: JDulmaa681@gmail.com



ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЯНАЛТ

1. ИТХ-ын дэргэд
“Эмэгтэйчүүдийн
манлайллын клуб”
байгуулсан.

2. Суман дахь төрийн
үйлчилгээний сургууль,
цэцэрлэг, эмнэлэг зэрэг
байгууллагын
нийтийн гал тогоо болон
талх, боовны цехийн сав
суулга, тосны хэрэглээ,
цэвэрлэгээний бодист хяналт,
шалгалт хийсэн.

3. Төсөвт хүндрэл
учруулахгүйгээр,
хуванцар шанага, шүүр,
усны сав зэргийг эрүүл
мэндэд нийцтэй сав
суулгаар солиулж, халуун
боловсруулалтаас хоол
хүнсэнд химийн бодис
шингэж орохоос сэргийлж
чадсан.



*Харилцах хаяг: Говь алтай аймгийн Бигэр сумын ИТХ-н Эмэгтэй төлөөлөгчид
С. Элбэрэлт, Утас: 8809-6433, 9519-0601*

НУТГИЙН УДИРДЛАГАД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН МАНЛАЙЛАЛ

Эмэгтэй төлөөлөгчдийн сайн туршлага



ХАМТЫН МАНЛАЙЛАЛ

1. Сэлэнгэ аймгийн Нэгдсэн эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад хамтын манлайллын загварыг ашиглаж, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг дээшлүүлсэн.

2. Багуудын ажлын төлөвлөгөөний дагуу хөрөнгө шаардлагатай зарим ажил үйлчилгээг Аймгийн ИТХ, Засаг даргад танилцуулснаар халаалт сайжруулахад 80 сая төгрөг, амбулаторийн засварт 342 сая төгрөгийг аймгийн төсөвт суулгуулж, аймгийн ИТХ-аар батлуулсан.

3. 2019 оны төсөвт хүчилтөрөгчийн хийн систем 257 сая, нэгдсэн эмнэлгийн сувиллын зураг төслийн зардал 14 сая, тархины цахилгаан бичлэгийн аппарат 30 сая зэрэгт хөрөнгө оруулалт хийх зардлыг 2019 оны орон нутгийн төсөвт суулгаж батлуулсан.



*Харилцах хаяг: Сэлэнгэ аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга, Аймгийн ИТХ-ын төлөөлөгч
Ц. Эрдэнэчимэг, Утас: 9903-4645, и-мэйл хаяг: ts.chimeg63@gmail.com*

НУТГИЙН УДИРДЛАГАД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН МАНЛАЙЛАЛ

Эмэгтэй төлөөлөгчдийн сайн туршлага



ДОТУУР БАЙР - ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ОРЧИН

1. Аймгийн Боловсрол, соёлын газарт дотуур байрны орчин нөхцлийг сайжруулах, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх чиглэлээр ямар бодлого, арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа талаар асуулга тавьснаар дотуур байрны асуудалд аймаг дахь боловсролын салбарын удирдлагуудын анхаарлыг хандуулж чадсан.

2. Дотуур байрны хүүхдийн хөгжил, хамгааллын асуудлаар Зөвлөмж гарган бүх сумдын Засаг дарга, Ерөнхий боловсролын 29 сургуульд хүргүүлсэн ба олон талын хамтын ажиллагааны эхлэлийг тавиад байна.



Харилцах хаяг: Өвөрхангай аймгийн ИТХ-ын 3-р тойргийн төлөөлөгч Т.Нарангарав
Утас: 94119449, и-мэйл хаяг: t.narangarav888@gmail.com

НУТГИЙН УДИРДЛАГАД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН МАНЛАЙЛАЛ

Эмэгтэй төлөөлөгчдийн сайн туршлага



30 ТН ХАЯГДАЛ ЦААСЫГ БАЯЛАГ БОЛГОН ДАХИН АШИГЛАСАН

1. Баянзүрх дүүргийн
7 хорооноос сард
нийтдээ 3,300 тонн
хог хаягдал гардаг.



2. Нийт хог хаягдлын
60 хувийг эзэлдэг
цаасыг ялгаж,
Монголын анхны
цаасны үйлдвэрт
дахин ашиглах
боломжтой түүхий
эд болгон нийлүүлж
байна.



Харилцах хаяг: Баянзүрх дүүргийн ИТХ-ын төлөөлөгч,
Нийтлэг үйлчилгээний газар-2 ОНӨААТҮГ-ын дарга, Д.Нэргүй Утас 8818-8155, e-mail: zovloh.ith@gmail.com

НУТГИЙН УДИРДЛАГАД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН МАНЛАЙЛАЛ

Эмэгтэй төлөөлөгчдийн сайн туршлага



СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГ ИРГЭД ХЯНАДАГ БОЛЖЭЭ

1. “Сум хөгжүүлэх сан”-гийн зээл олголт, эргэн төлөлтөд иргэд хяналт тавих журмыг ИТХ-аар батлуулсан.

2. Энэ нь “сайн туршлага” болж үндэсний түвшинд түгээгдсэн төдийгүй Засгийн газрын “Сум хөгжүүлэх сан”-гийн журамд өөрчлөлт ороход нөлөөлсөн.



Харилцах хаяг: Ц.Номин, Чандмань-Өндөр сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга
Утас: 99164819, e-mail: nomio_ts@yahoo.com

